



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

### Деметри Севастопуло

Тагнуулын төв газрын дарга асан Жон Бреннан мягмар гарагт конгресст өгсөн мэдүүлэгтээ Оросын тагнуулын албад өнгөрсөн оны сонгуулийн сурталчилгааны үеэр Дональд Трампын туслахуудыг элсүүлсэн байж магадгүй хэмээн сэтгэл түгшиж байснаа хүлээжээ. Тэрбээр төлөөлөгчдийн танхимын тагнуулын хороонд хэлсэн үгэндээ “Намайг нэгдүгээр сарын 20-нд огцруулах үед шийдэгдээгүй асуудал байсан... Оросууд сурталчилгаанд оролцогчдыг талдаа татахад амжилтад хүрсэн эсэх, сайн дураар буюу албадах аргаар уу гэх мэт” хэмээн тэмдэглэжээ.

ТТГ-ын дарга болохоосоо өмнө Барак Обамагийн зөвлөх байсан ноён Бреннан цааш нь Трампын баг болон Оросын хоорондын холбооны талаар Холбооны мөрдөх товчооны мөрдөн байцаалт “сайн үндэслэлтэй” гэж онцолсон байна. Өнгөрсөн долоо хоногт Шүүх яам хуучин ХМТ-ны босс асан Роберт Мюллерийг бие даасан мөрдөн байцаалтын ахлагчаар томилсон. Ерөнхийлөгч Трамп уг асуудлаар мөрдөлтийг зогсоохыг албаныханд шахалт үзүүлсэн тухай мэдээ тараад буй. Тухайлбал, АНУ-ын үндэсний тагнуулын албадын тэргүүн Дэн Коэте Трампын зүгээс ХМТ-ны мөрдөлтийн хүрээг багасгах хүсэлт ирсэн талаар тайлбар өгөхөөс татгалзсан юм. Тэрбээр сенатын зэвсэгт хүчний хороонд үг хэлэхдээ “Энэ талаар нийтийн өмнө тайлбар өгөх нь зохимжгүй” хэмээн өгүүлжээ.

Washington Post сонинд Ерөнхийлөгч ноён Коэте болон Үндэсний аюулаас хамгаалах агентлагийн тэргүүн адмирал Майкл Рожерс нарт хандаж, түүний сурталчилгаа Оростой холбоогүйг мэдэгдэх хүсэлт тавьсан аж. Цагаан ордон ийнхүү шуугианд нэрвэгдэн импичментийн асуудал сөхөгдсөнгийг Ерөнхийлөгч асан Ричард Никсоны Уотергейтийн хэрэгтэй адилтгаж байгаа юм. Гэвч засаг захиргааны төлөөлөгч мягмар гарагийн хэлэлцүүлгийн талаар “Мөрдөн байцаалт жил үргэлжилж байгаа ч Орос, Трампын холбоог нотлох баримт алга” хэмээн мэдэгдэв.

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Оросын оролцоог



BBM©

# Ерөнхийлөгчөө сэрдсэн АНУ-ын тагнуулын алба

тойрсон дуулианы улмаас ХМТ-ны захирал Жеймс Коми ажлаасаа халагдсан. Шалтгааныг нь Хиллари Клинтоны хувийн мэйлийг шалгасан хэрэгтэй холбон тайлбарлаж байв. Гэвч ноён Трамп туслахуудынхаа тайлбартай зөрчилдөж, Оросын явдлаас болсон мэтээр ярьжээ. Ерөнхийлөгч хувийн уулзалтын үеэр Комид шахалт үзүүлж, сурталчилгааныг нь зөвлөх асан Майкл Флиннийг байцаалтаас

чөлөөлөх санал тавьсан тухай мэдээ гарсан нь бас гал дээр тос хийхтэй адил болсон байна. Флиннийг Цагаан ордны зөвлөхөөр томилоод байсан авч сар хүрэлгүй Оросын Элчин сайдтай уулзсан тухайгаа ташаа мэдээлсэн гэдэг шалтгаанаар халахад хүрсэн билээ.

Ноён Мюллерийг мөрдөн байцаалтын ахлагчаар томилсны дараа Ерөнхийлөгч энэхүү шуугианыг “шулам ангуучлах”

хэмээн нэрлэжээ. Трамп Оросын Гадаад хэргийн сайд Лавровтой уулзах үедээ ноён Комийг хатуу самар хэмээн нэрлээд түүнийг халсан нь Оросын талаарх дарамтыг зөөлрүүлнэ гэж хэлсэн тухай мэдээлэл алдагдаж, New York Times сонинд нийтлэгдэв. Ерөнхийлөгчийг Оросын сайдад алан хядагчдын дунд нэвтэрсэн тагнуулын нууц мэдээ зардуулсан хэмээн буруутгасан байна. Трамп даваа гарагт Тель

Авивт айлчлахдаа “Оросуудтай ярилцахдаа би Израилийн тухай үг хэлээгүй” гэсэн нь Израилийн тагнуулд ажилладаг мэдээлэгчийг зардуулаагүй шүү хэмээн өөрийгөө зөвтгөж байгаа мэт сонсогдсоныг сэтгүүлчид шүүмжлэн бичжээ.

Төлөөлөгчдийн танхимд болсон хэлэлцүүлэг дээр ноён Бреннан тагнуулын мэдээллийн эх сурвалжийг зардуулах нь маш хортой онцлоод зардуулагчийг заавал

илрүүлэх ёстой гэжээ. Гэхдээ ноён Трампын хувьд нууцыг хуваах тухай хоёр протоколыг зөрчсөн байж болзошгүйг сануулсан байна. Бреннан АНУ-ын тагнуулын албад гадаадын тагнуулын албадтай нууцаа солилцдог болохоос айлчлалаар ирсэн сайдад мэдээлэл өгдөггүй хэмээн онцлоод мэдээлэл хуваах бол эх сурвалж болох байгууллагаас нь зөвшөөрөл авах ёстой байдаг гэжээ.



## Дрон ажиллах нөхцөлийг өөрчилнө

### Женнифер Томсон

Долоон жилийн өмнө Жеймс Харрисон дроныг бизнес хэрхэн ашиглах талаар судалгаа хийн, ширээнийхээ ард толгойгоо гашилгаж байв. Британийн армиас дөнгөж халагдсан тэрбээр хоёр нөхрийн хамт компани байгуулж, нисэгчгүй онгоцыг аль салбарт хэрэглэвэл ашигтайг эрж хайсан гэнэ. Харрисон нефтийн цамхгийн зургууд үзэж байтал далай дахь нефтийн цамхгийн гадаргын аюулгүй байдлыг троссонд дүүжлэгдэн шалгаж буй ажилчдын дүрс тааралдсан гэнэ. Түүнийг Афганистанд алба хааж байхад дайсны байрлалыг дроны технологи ашиглан агаараас тандах арга нэвтэрсэн байв. Тэрбээр цамхгийн аюулгүй байдлыг хянахад дрон тусалж болохыг ойлгосон байна.

Ноён Харрисоны байгуулсан Sky-Futures нэртэй компани одоо Ели хэмээх Италийн хий үйлдвэрлэгч зэрэг хэрэглэгчдэд хяналтын үйлчилгээ үзүүлж байна. Ажилчид хүрэхэд хүнд хэсэг рүү оосроор бөхлэн очихын оронд төхөөрөмжөө хөөргөөд байгууламжийн гаднах ан цав, элэгдлийг илрүүлэх боломж нээгдэв. Дроноос авсан зургийг аюулаас хамгаалах ажилтнууд эргэн тоглуулж үзээд ямар арга хэмжээ авахаа төлөвлөнө. Харрисон “Троссоос зүүгдэн шалгалт хийснээс хавьгүй бага зардалтай” хэмээн өгүүлээ.

Цамхгийг шалгах дрон ажлын байрыг өөрчилж буй зөвхөн нэг жишээ энэ. Норфолкын фермер Крис Эллингтон Хятадад үйлдвэрлэсэн, 15000 паундын үнэтэй



BBM©

дрон ашиглан, хоёр метр хүртэл өндөр ургадаг тосны ургамлын тариаланд өвчлөл үүссэн эсэх, байгаль орчинд хохирол учруулж буй байдлыг хянадаг аж. Тэрбээр “Тодорхой өндөр хүртэл ургахаар очиж үзэх боломжгүй болдог. Дроноос бол гайхалтай нарийн харагддаг” гэнэ. Ноён Эллингтон бас Stop Angel хэмээх компани үндэслэж, тариаланг агаараас хянах үйлчилгээ санал болгодог авч олонх фермер өөрсдөө дрон худалдан авахыг илүүд үздэг байна.

Дэлхий даяар эртний байгууламжийг эрж хайх ажилд дрон ашигласнаар археологийн су-

далгаа мөн өөрчлөгдөж байгаа. Иорданы өмнөд нутагт оршдог МЭӨ 3600-3200 оны үеийн эртний булшийг 1980-аад оноос хойш хулгайч нар талхлах болжээ. Эндээс авсан ваар сав хар зах дээр 200-300 ам.долларын үнэ хүрдэг. Археологичид уг газрыг хамгаалахын тулд явганаар эргүүл хийдэг байсан одоо дрон тэдний оронд ажиллах боллоо. Энд ажиллаж байсан Чикагогийн их сургуулийн археологич Мораг Керсел өдөр бүр дрон нисгэхээс ажлаа эхэлдэг байснаа дурсав. Тэрбээр “Дрон төсөл хэрэгжих хугацааг асар их өөрчилсөн. Бид нэг шөнийн дотор газрын зураглал хийдэг болсон” гэжээ.

Тэд анхандаа дроныг өөрсдөө угсарчээ. Төхөөрөмж дээрээ Go-Pro хэмээх камер суурилуулж, их биед нь доош чиглэсэн дурантай Canon 100 зургийн аппарат байрлуулсан нь 2-3 секундэд нэг зураг дардаг байна. 2016 онд бичлэг хийж, зураг авдаг DJI Phantom 3 нисдэг төхөөрөмжийг онлайнгаар 500 ам.доллараар худалдан авсан байна. Дроноос авсан зурагт газрын хөрсний өнгө өөрчлөгдөн харагдвал тэнд хүний гар хүрснийг мэддэг аж. Профессор Керсел цааш нь ярихдаа “Дээрээс авсан зураг хөрсний талаар бидний төсөөллийг өөрчилсөн. Хиймэл дагуулаас авсан зураг хангалттай тод гардаггүй. Газраас хараад илрүүлэх боломжгүй өөрчлөлтийг бид агаарын зургаас олж чадна” хэмээн өгүүлээ.



## Японы корпорацийн шинэчлэл удаашрав

### Лео Льюс

Японы хувьцааны үйлчилгээний хамгийн том компани болох Secom-ийн тайлан нийтлэгджээ. Тус компани санхүүгийн бус тэтгэврийн сангууд дотроос ганцаараа 2014 онд тайлангаа ил болгох Удирдлагын журам, гэрээнд гарын үсэг зурсан юм. Toyota, Panasonic мэтийн аж үйлдвэрийн аваргууд уг журамд нэгдээгүй аж. Нийтдээ Японы нэр хүнд бүхий 600 орчим тэтгэврийн сан жил бүрийн уулзалтад санал өгсөн байдал, компанийн менежментийн стандартыг сайжруулах журмыг хэрэгжүүлэхээс татгалзсан байдаг. Компаниуд олон арван жилийн турш ажиллагсдынхаа эрх ашгийг дээдэлдэг хэмээн сурталчилсан хэрнээ тэтгэврийн сангийн менежментийг сайжруулах журмыг үл тоомсорлосон нь гайхалтай.

Гэвч Secom-ийн тайлангаас корпорацийн удирдлагын шинэчлэл удааширсан хэдий ч цаашдаа юунд хүргэхийг таамаглаж болохоор байна. Эндээс үзэхэд Японы корпорацийн удирдлагын шинэчлэл Ерөнхий сайд Шинзо Абэ, бүх төрлийн хөрөнгө оруулагчид болон өөрчлөгдөх дургүй корпорациудад томоохон сорилт болох нь тодорхой. Зургадугаар сард Японы олонх компанийн тайлангийн хурал болдог агаад Удирдлагын журам хоёр жилд хэрхэн хэрэгжсэн болон гадаадын томоохон хөрөнгө оруулагчид Японд орж ирсэн



BBM©

талаар үзүүлэлт гарах ёстой.

Өөдрөг үзэлтнүүд Secom-ийн тайланг ганц жишээ бус, эхлэн хэрэгжүүлэгч гэдэг өнцгөөс харж, дэвшил гарлаа гэж үнэлсэн байна. Сүүлийн хоёр жилд Японы компаниуд захирлуудын зөвлөлдөө гаднаас хүн авах нь нэмэгджээ. Журам гарахаас өмнө компаниудын 22 хувь нь зөвлөлдөө гаднын захиралтай байсан бол одоо тавны дөрөв нь ийм болсон байна. 2017 он даруухан эхэлсэн боловч хоёр жилд хувьцааны эргэн худалдан авалт эрс нэмэгдэж, хувьцааны өгөөж гэдэг нэр томьёо Японы хөрөнгө оруулалтын хэлэнд нэвтэрч эхлэв.

Нөгөө талаас удирдлагын шинэчлэл үл тоомсорлох, эс хүлцэх байдалтай тулгаран эцэстээ нурна гэж үздэг хүмүүс бас Secom-ийг муу жишээ болгон тайлбарлах боломжтой. Тухайлбал, том компаниуд биржид бүртгэлтэй салбаруудаа худалдан авсан тоо олширсон нь хоёрдогч хувьцаа эзэмшигчдийн эрхийг ноцтой зөрчсөн явдал юм. Тэтгэврийн сангууд нь дээрх журамд гарын үсэг зураагүй агаад яагаад татгалз-

санаа ч тайлбарлахгүй байгаа Toyota, Panasonic зэрэг томоохон компаниудын хувьд Secom-ийн жишээ түгшүүртэй байж магадгүй. Учир нь томоохон компаниудын бүртгэлтэй салбаруудтайгаа харилцах бизнесийн харилцаанд нөлөөлөх боломжтой. Ялангуяа Toyota, Panasonic хоёр уг асуудлаас болж бусад компанийн анхаарлын төвд ирээд байна.

Удирдлагын журамд гарын үсэг зурсан компанийн тоо ийм цөөн байгаа нь том корпорациуд хойш сууснаас шалтгаалдаг гэж жижгэвтэр компанийн захирлууд ярьжээ. Хэрэв энэ хоёр аварга санаа бодлоо өөрчилбөл хэдэн зуун корпорацийн тэтгэврийн сан үлгэр жишээг нь дагах байх гэж шинжээчид үздэг. Ингэсэн тохиолдолд ганц шөнийн дотор хувьцаа эзэмшигчдэдээ нээлттэй, хувьцааг нь эзэмшдэг компаниуддаа шаардлага тавьдаг хөрөнгө оруулагч сангуудын булэг бий болно. Энэ нь чухамдаа Удирдлагын журмын үндсэн зорилт агаад корпорациудын болгоомжлоод буй ганц шалтгаан юм.

